



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/292

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Усны эх үүсвэрийг хамгаалах, хуримтлуулах, зүй зохистой ашиглах зорилгоор усан хангамжийн төвлөрсөн шугам сүлжээний 1-р шатны ажил (Могод сум)-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Баатаршүтээн Уул” ХХК-тай 991,049,808 (есөн зуун ерэн нэгэн сая дөчин есөн мянга найман зуун найм) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Баатаршүтээн Уул” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Хонгорзул)-д даалгасугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгүүлж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010394

Аймгийн Засаг даргын 2025 оны  
05 дүгээр сарын 05-ны/ний өдрийн  
Х/292 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 210 хоног	Ү.Бямбасүрэн
2	Баталгааны хугацаа	36 сар	Ү.Бямбасүрэн
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Э.Эрдэнэжаргал Ү.Бямбасүрэн
4	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Э.Эрдэнэжаргал
5	Захиалагчийн техник хяналтын зардал	17,208,713 төгрөг	Ү.Бямбасүрэн
6	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	8,604,357 төгрөг	Ү.Бямбасүрэн
7	Магадалшгүй ажил	17,208,713 төгрөг	Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Э.Эрдэнэжаргал